


2. Удирдлагын зарчим

Удирдлагыг ойлгохын тулд хамгийн гол нь Бурханы тогтоосон эрх мэдлийн хүрээ болох *эцэг эх, засаг төр, сүмийн удирдлага, ажил олгогч* гэсэн дөрвөн талбарыг тодорхойлох хэрэгтэй. Ямар нэг шийдвэр гаргахдаа “хэний эрх мэдлийн хүрээнд байна” гэдгийг бид бодож үзэх ёстой. Бурхан эрх мэдэл бүхий хүмүүсээр дамжуулан Өөрийн заавар чиглэл, хамгаалалт, хангалтыг өгдөг. Бид тэдний эсрэг тэрсэлбэл тодорхой газар, тодорхой хүмүүст өөрийн эрх дархаа тогтоодог *бузар хүчний засаг захиргааны* хор хөнөөлд өөрсдийгөө ил гарган тавьж өгч байгаа хэрэг юм. Тийм учраас “*тэрслэх нь ид шидийн нүгэл адил*” гэж хэлсэн байдаг (1 Самуел 15:23-ыг үз).

Яагаад зарим удирдлага хэцүү хатуу байдаг вэ?



Зан чанарын сургалт хэрэгтэйн учир

Бурхан эцсийн эцэст зан чанарыг маань төлөвшүүлэхэд л голлон анхаардаг. Үүний тулд ихэвчлэн хэцүү хүмүүсийг ашигладаг. Иосеф боол болон худалдагдаж хожим гүтгэгдэн шоронд орсон байдаг. Энэ нь хожим түүний амьдралаар хэрэгжүүлэх гэж Бурханы зорьсон зорилгыг биелүүлэх бэлтгэл “сургууль” болсон юм. Бага залуудаа сураагүй зан чанарын сургалт хожим том болсон хойно давтагдах ёстой болдог. Тийм ч учраас насанд хүрсэн олон хүний зөрчил тэмцэл өсвөр насанд нь шийдвэрлэгдээгүй зөрчил байдаг.

ЯАГААД ЗӨРЧИЛ ГАРДАГ ВЭ?

Удирдлагаас хууль дүрэм тогтоогддог бөгөөд эрх мэдлийнх нь дор байгаа хүмүүс эх зах, хил хязгаарыг шалган турших хандлагатай байдаг тул удирдлагын аль ч бүтцэд зөрчил гардаг. Бурхан Адам Ева хоёрт ганцхан хориг тавьсан бөгөөд тэр хоёр түүгээр шалгагдсан билээ. Удирдлагын зүгээс мэргэн ухаан, төлөвшилт, хайр харуулахгүй байгаа бол нэмэлт зөрчил гардаг.

Биелэгдээгүй амлалтууд

Горьдлого тээх нь харилцаанд сэв суулгадаг. Удирдлага амласнаа биелүүлэхгүй байснаар эрх мэдэл дороо буй хүмүүсийг гомдоодог. Тэрхүү гомдлыг тэр даруй тайлахгүй бол гашуун хор бүхий үндэс ургуулж “...түүгээр олон хүн бузарлагдах...” болдог (Еврей 12:15).

Бардамнал

[Их зан л маргаан мэтгэлцээнд хүргэдэг] (Сургаалт үгс 13:10). Бардамнал нь бусдын хэрэгцээ шаардлагыг үл тоон өөрийгөө бодож хувиа хичээж байдаг чанар юм. Бардамнал нь эцсийн шийдвэр гаргах эрхийг өөртөө авч Бурханаас өгсөн удирдлагын заавар чиглүүлэлтэд захирагдахгүй байх явдал юм. Бардамнал нь өөрийгөө бусдаас дээр, бусад хүн өөрөөс нь дор гэж бодож шүүх үзэл юм. Бардамнал нь гомдоосон хүнээсээ уучлал гуйхаас татгалзах явдал юм.

Уур уцаар

“Шударга бус явдлыг (дураараа авирлах, ялангуяа ёс суртахууны ялзралд автах) тариалагч нь хов хоосонг хураана. Түүний уур хилэнгийн саваа мод ч [устана]” (Сургаалт үгс 22:8). Арван тушаалын тавдугаарх нь хүүхдэд эцэг эхээ хүндлэхийг заасан байдаг. Гэхдээ Бурхан эцгүүдийг ч гэсэн хүүхдүүдээ уур хилэнд өдөөн хатгаж болохгүй гэж зааварласан байдаг (Ефес 6:4-ыг үз). Эцэг хүн урам нь хугарахдаа хүүхдэдээ уурлаж тэр уураараа сахилгажуулбал сэтгэлийг нь шархлуулж уур хилэнг нь ноцоодог.

Удирдагч хүний хийвэл зохих ухаалаг шалгуур

Ирээдүйд хийх гэж хүсч буй зүйлийнхээ талаар хэлсэн үг тань бусдад хэчнээн их горьдлого төрүүлдгийг мэдвэл та гайхахад хүрч магадгүй юм. Удирдлага дороо байгаа хүн нэг бүрээс “Би та нарт амлалчаад биелүүлээгүй юм байгаа юу?” гэж асууж бай. Тэгээд шалавхан тэмдэглэж авахад бэлэн бай. Хэлсэн зүйлийн тань талаарх тэдний ойлголтыг засах гэж бүү марга. Харин тэр нь боломжтой юм байвал үг дуутгүй биелүүд.

Охид хөвгүүдээс “Аавыгаа ямар хоёр зүйлээр өөрчлөгдөөсэй гэж хүсч байна вэ?” гэж асуухад тэд ихэвчлэн “Уурлахаа болиосой, буруу юм хийсэн үедээ уучлал гуйдаг байгаасай” гэж хариулдаг. Энэ хоёр чанарыг эзэмших юм бол дараагийн хүснэгтээр үзүүлсэн эмгэнэлт хор уршгаас сэргийлэх болно.

ЭРҮҮЛ БУС ХАРИЛЦАА ГАЗАР АВАХ

ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУ ҮЙЛДЭЛ	ӨСВӨР НАСНЫХАНД ИЛРЭХ ШИНЖ	ТАЛБАР	ӨСВӨР НАСНЫХНЫ ДОТООД ЗӨРЧИЛ	ЗӨВ ОЙЛГОЛТ
			1.	
			2.	
			3.	
			4.	
			5.	
			6.	
			7.	
			8.	

ӨӨРИЙГӨӨ ХОРЛОХ ДӨРВӨН ХЭЛБЭР

**1. ОЮУН
САНААНЫ**

(Мансууруулах бодис,
хуурамч сургаал)

**2. ЁС
СУРТАХУУНЫ**

(Бузар хүсэлдээ автан
бууж өгөх)

3. СҮНСНИЙ

(Илбэ шид)

**4. БИЕ
МАХБОДЫН**

(Үхэл)

ӨӨРИЙГӨӨ ХОРЛОХ ДӨРВӨН ТӨРӨЛ

1. ОЮУН САНААГАА ХОРЛОХ: Мансууруулах бодис, хуурамч сургаал

- Мансууруулах бодис: Хариуцлага хүлээх чадвар буурах — *2 Коринт 10:5*
Эмчилгээ: Мацаг барих, Бичээс цээжлэх
- Хуурамч сургаал: Христийн дагуу биш сургах — *Колоссай 2:8*
Эмчилгээ: Дээрхийн адил

2. ЁС СУРТАХУУНАА ХОРЛОХ: Бузар хүсэлдээ автан бууж өгөх

- Бузар мууг эсэргүүцэх = Амьдралын үндэс
- Шунан дурлахын үр дагавар = Улам их шунан дурлах — *Галат 6:7*

3. СҮНСЭЭ ХОРЛОХ: Далдын бузар хүчний илбэ шидийн үйл ажиллагаанд оролцох

- Улс үндэстний сүйрлийн гурван үе шат
 1. Бурханы Үгийг эсэргүүцэх
 2. Бузар явдлыг хүлээн авах
 3. Сатаныг шүтэх
- Үр дагавар нь:
 1. Утга учиргүй айдаст автах
 2. Тайлбарлах аргагүй сандран тэвдэх
 3. Авцалдаагүй сэтгэх, зөв тодорхой сэтгэн бодох чадваргүй болох
 4. Бурхантай харилцах чадваргүй болох
- Шийдвэр
 1. Бузар хүчний үйл ажиллагаанд оролцсон гэм нүглээ улайх — *1 Иохан 1:9*
 2. Эзэн Есүс Христийн нэр ба цусыг нэхэмжлэх — *Илчлэлт 12:11*

4. БИЕ МАХБОДОО ХОРЛОХ: Үхэл — *Еврей 9:27*

Гомдол хорслын цайзуудыг нураах нь

Бууж өгч алдсан “газар”-ыг буцааж авснаар ёс суртахууны цэвэр ариун байдлыг бий болгодог.

1. Гомдол хорслыг хүснэгтээр зурж тайлбарлаж сур.

- **Эхлээд дөрвөлжин шугамтай хүснэгт зур**—Энэ нь бидний сэтгэл санааг төлөөлнө (оюун ухаан, хүсэл эрмэлзэл, сэтгэлийн хөдөлгөөн).
- **Нэг дөрвөлжинг сонгоод хардуул**—Ефес 4:26-32-т бид хэн нэгний эсрэг гомдож хорсохдоо сэтгэлийнхээ нэг хэсэг газрыг Сатанд олгочихдог гэжээ. Тэгээд Сатан авсан газар дээрээ цайзаа барих зүй ёсны эрхтэй болдог.
- **Цайзыг зур**—Цайз нь Бурханы хүслийн эсрэг үзэл бодол юм. Сатан өөрийн цайзаас биднийг айдас, уур уцаар, санаа зовнил зэрэг элдвийн хөнөөх зовлонгоор тарчлааж байдаг.
- **Бусад дөрвөлжин рүү сум заа**—Бид өөрсдийг маань гомдоосон хүмүүсийг уучилж чадахгүй байвал Бурхан биднийг зандалчдад тушаана гэж Бичээст хэлсэн байдаг. Бид өөрсдөө зандалчдын эсрэг тэмцэх гэж оролдвол Сатан зүгээр л цайздаа буцаж ороод дахин дайрах боломжийг хүлээн отдог. Цайзыг нураатал бид жинхэнэ эрх чөлөөг ер авч чадахгүй. Гэхдээ Бурхан л тухайн газрыг буцаан авч өгөхгүй юм бол бид өөрсдөө цайзыг нурааж чадахгүй.
- **Авах арга хэмжээг бич**—Алхам бүрийг тайлбарлаж холбогдох Бичээсийг иш тат. Тухайн хүн гомдол хорслыг ялахыг хүсч байгаа эсэхийг нь асуу.
- **Тухайн хүнийг дараагийн хуудаст буй дөрвөн заалтын эхний гурвыг хийхэд нь дагуулан залбир**—Тэгээд гомдож хорссон хүнээ уучлахдаа тусдаа залбирахыг уриал.

2. Хүснэгтэд хэрэглэгдсэн гол ишлэлүүдийг цээжлэгтүн.

- | | | |
|---------------------------------------|--|---|
| <input type="checkbox"/> Еврей 4:12 | <input type="checkbox"/> Ефес 4:26-27 | <input type="checkbox"/> 2 Коринт 10:1-5 |
| <input type="checkbox"/> Матай 18:34 | <input type="checkbox"/> Ефес 6:12 | <input type="checkbox"/> Еврей 12:15 |
| <input type="checkbox"/> 1 Иохан 1:9 | <input type="checkbox"/> 1 Иохан 2:9 | <input type="checkbox"/> Дуулал 23:3 |
| <input type="checkbox"/> Ефес 4:31-32 | <input type="checkbox"/> Илчлэлт 12:11 | <input type="checkbox"/> Колоссай 2:14-15 |

3. Гомдол хорслын цайзыг хэрхэн нурааснаа бич.

Эндээс мэдэж авсан зүйлээ хэрэгжүүлсэн туршлагаа бичиж тэмдэглэ. Гомдол, хорслоо ялснаар Бурхан таны амьдралд ямар зан чанар бий болгосныг жагсаан бич.

4. Бусдыг гомдол хорслоо ялахад нь хэрхэн тусалснаа тэмдэглэдэг дэвтэртэй бай.


Эндээс мэдсэн зүйлээ хуваалцсан хүнийхээ санал бодол, асуултыг тэмдэглэн хадгал. Хийсэн ярилцлагынхаа талаар бодож байхдаа зовлонгийн тухай энэхүү нийтлэг зарчмын талаар шинэ ойлголт, шинэ хэрэглээг олж харах болно.

5. Тусалж байгаа хүндээ гэрчлэлээ бичиж тэмдэглэхийг уриал.

Таны ярилцсан хүн үнэхээр хорсол гомдлоосоо чөлөөлөгдсөн нь цаг хугацаагаар нотлогдвол гэрчлэлийг бичүүлж нэг хувийг авах хүсэлтэй байгаагаа хэлж бай. Эдгээр нь зөвхөн тэднийг урамшуулаад зогсохгүй хорсол гомдлын цайзыг хэрхэн нураах талаар илүү ойлголттой болоход тань туслах болно.

СЭТГЭЛ ДЭХ ТУЛААНЫ ТАЛБАР

Гомдол хорслын цайзуудыг нураах нь



Сэтгэл: Оюун ухаан, хүсэл эрмэлзэл, сэтгэлийн хөдөлгөөн сүнсний эсрэг (Грекээр псүкэ)—*Еврей 4:12*

Газар: Эрх мэдлийн харъяаны газар (Бидний сэтгэл санааны нэг хэсэг)—*Ефес 4:27*

Цайз: Бичээстэй нийцэхгүй сэтгэлгээ ба дүгнэлт—*2 Коринт 10:4-5*

“Зандалчид”: Бидэнд өршөөж энэрэхийг сургахаар Бурханаас зөвшөөрөгдсөн зовлон шаналал—*Матай 18:34*

Бузар хүчний засаг захиргаа: Эрх мэдлийн нь харъяанд буй газрыг захирч буй бузар хүчний удирдагч—*Ефес 6:12*

Авах арга хэмжээ:

1. Хорсож гомдсон гэмээ улайх—*Еврей 12:15, 1 Иохан 1:9*
2. Бууж өгч алдсан газрыг буцааж авч өгөхийг Бурханаас гуйх—*Дуулал 23:3*
3. Цайзуудыг үнэний хүчээр эвдэж нураах—*2 Коринт 10:4-5*
4. Гомдоогчоо уучилснаар өршөөл үзүүлэх—*Матай 6:14-15*

Гомдол хорслын цайзуудыг хэрхэн нураах талаар хуваалцах гол санаа

Сэтгэл

• АСУУДАЛ

- Гомдол хорсол нь бидний сэтгэлийг бузарладаг.

“Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариусгалыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй болой” гэсэнчлэн Бурханы нигүүдслийг эсэргүүцэхээс сэрэмжлэх ёстой. Тэгэхгүй бол “олон хүн бузарлагдах...” аюултай гашуун үндэс бидний дотор амархан бий болдог (Еврей 12:14-15-ыг үз).

• ҮР ДАГАВАР

- Гомдол хорсол сэтгэлийн тэнхээг бардаг.

Хэрвээ бид бузар муу зүйлийн хойноос тэмүүлээд байвал зүрх сэтгэлд байгаа бузар хүсэл биелэхийг Бурхан зөвшөөрч болох юм. Гэхдээ сэтгэлийг маань эцээх өвчинг хамт илгээнэ (Дуулал 106:15-ыг үз). Энэ өвчин нь Бурханы замаар замнаж Түүнтэй харилцах сэтгэлийн чадавхыг бууруулдаг.

• ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

- Эзлэгдсэн газрыг буцаан авч болно.

“Тэр миний сэтгэлийг сэргээдэг” гэж Дуулал 23:3-т хэлсэн нь онцгой анхаарах зүйл юм. Бидний хоньчин Эзэний хувьд Тэр биднийг “зөвийн замаар хөтөлж” “бидний дайснуудын өмнө бидэнд ширээ засдаг” билээ (Дуулал 23:3, 5-ыг үз).

“Газар”

• ТОДОРХОЙЛОЛТ

- Сэтгэл санааны нэг харъяа газар.

Гомдол хорсол нь “Диаволд байр өгдөг” гэж бидэнд Ефес 4:27-д сануулсан юм. Байр гэдэг грек үг нь “харъяа газар” гэсэн утгатай байдаг аж. Хаант засаглал бүхий улсад хааны эрх мэдэл дор буй газрыг түүний харъяа газар гэдэг байна.

• АСУУДАЛ

- Эзлэгдсэн газар нь тарчлал шаналал авчирдаг.

Диавол хүний сэтгэлд байр олж авснаар түүн дээрээ цайз барьж, сэтгэлийн бусад талбарыг тарчлаан зовоох бааз болгон ашиглах зүй ёсны эрхтэй болдог.

• ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

- Эзлэгдсэн газрыг алхам алхмаар буцааж авдаг.

Ефес 4:26-32-т хэлсэнчлэн уур хилэн дээрээ нар жаргахыг зөвшөөрөх болгондоо бид Сатанд илүү их газар өгдөг. Бидэнд гомдол хорсол төрүүдсэн олон хүн байж болох юм. Дайн байлдааны үед дайсанд алдсан газраа алхам алхмаар буцааж авах ёстой байдаг.

Цайзууд

• ТОДОРХОЙЛОЛТ

- Буруу сэтгэлгээ

Бурхан “Христийн дагуу биш, харин ертөнцийн үндсэн зарчмууд, хүний уламжлалын дагуух” хоосон гүн ухаанаар мэхлэгдэх вий гэж бидэнд сануулсан байгаа (Колоссай 2:8-ыг үз). Иймэрхүү сургаалуудад автагдах нь Сатанд сэтгэлээ “олзлуулах” -ыг зөвшөөрч байгаа хэрэг юм.

• ҮР ДАГАВАР

- Бурханы хүслийн эсрэг шийдвэр

Сатан бидний ухаан санаанд Эзэний Үгийн эсрэг сэжүүр оруулаад үүнээсээ ургуулан буруу шийдвэр гаргах хүсэлтэй болгож нөлөөлдөг. Эдгээр буруу шийдвэр нь айдас, уур уцаар, гутрал, санаа зоволт зэрэг хор хөнөөлийг сэтгэлд бий болгодог.

• ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

□ Цайзуудыг нурааж болно.

Бидэнд “цайзуудыг эвдэж нураах Бурханы хүчит зэвсэг” өгөгдсөн байгаа (2 Коринт 10:4). Үнэний эдгээр зэвсэг нь бүх буруу сургаал, заль мэхтэй санааг нурааж бодол бүрийг маань Христийн сургаалын үнэн рүү авчрах зориулалттай юм.

ЦАЙЗУУДЫН ЖИШЭЭ

• “Намайг гомдоосон хүн хэзээ ч өөрчлөгдөхгүй.”

Сатан энэхүү буруу дүгнэлт дээр үндэслэн эхнэр нөхрийг салгах, үр хүүхдийг эцэг эхийнх нь эсрэг босгох, ажилтныг ажлаас гарах, сүмд хагарал бий болоход хүргэдэг.

Бурхан “Үзэгтүн Би бол ЭЗЭН, бүх махан биеийн Бурхан. Надад ямар нэгэн зүйл дэндүү хэцүү юү?” гэсэн байдаг (Иеремиа 32:27).

Бурхан эхнэр хүнийг номхон дөлгөөн, төлөв төвшин зантай байж чин сэтгэлээсээ нөхрөө хүндэтгэж сурснаар Бичээст итгэдэггүй түүнийг байлдан дагуулж болох юм гэж зааварласан байдаг (1 Петр 3:1-2-ыг үз).

Бурхан нөхөр хүнийг эхнэртээ гомдож хорсолгүй харин түүнийг хайрлахыг шаардсан байдаг. Нөхөр нь эхнэрээ агапэ хайр (Бурханы хайр) -аар хайрласан үед эхнэр нь үнэ цэнтэй “туслагч” болдог (Ефес 5:25-33-ыг үз).

• “Намайг гомдоосон хүнийг би шийтгэх ёстой.”

Гомдоогчид нь өөрсдийг нь уучлахыг хүссэн гомдогчдынхоо өгөөмөр хүсэлтийг хүлээн авахгүй байгаад байвал шийтгэнэ гэдгээ Бурхан амласан билээ. Хариу авах нь биднийх биш, бид Бурханы уур хилэнд зай гаргах ёстой. “...Өшөө авалт нь Минийх, Би буцааж төлнө гэж Эзэн айлдав” (Ром 12:19).

Бид хэрэг явдлыг гартаа авч өөрсдийг маань гомдоосон хүмүүст хариуг нь барих гэж оролдох юм бол хайрын хүчээр ялдаг хүмүүст Бурханы өгдөг онцгой ивээлийг алдаж өөрсдийн бие, сэтгэл санаа, харилцаанд сүйрэл авчрах болно.

Зандалчид

• ТОДОРХОЙЛОЛТ

□ Сэтгэл санааг зовоох бузар муугийн хүч

Асар их өрнөөсөө хэлтэрсэн нэгэн өөрт нь багахан өртэй байсан нэгнийг өрнөөс нь хэлтрүүлээгүй учир эзэн нь түүнийг зэмлэж, “...зандалчинд тушаажээ” (Матай 18:34, мөн 23-34-р ишлэлүүдийг үз).

Энэ хэсэгт гарч буй зандалчин гэдэг үгийн үйлийн хэлбэр нь грек хэлэнд “тарчилгах” гэсэн утгатай. Энэ үгийн үндэс нь “өвтгөх, хүнд хүчир хөдөлмөр хийлгэх, сэтгэлийн зовлон шаналгаанд оруулах” гэсэн утгатай.

• АСУУДАЛ

□ Бурхан гомдол хорсол тээсэн хүмүүс рүү зандалчдыг илгээдэг.

Шударга биш нярвын тухай сургаалт зүйрлэлд эзэн нь буруутныг уучлахаас татгалзсан зарцаа зэмлэж “...Би бүх өрийг чинь хэлтрүүлсэн. Би чамайг өршөөсний адил чи бас анд нөхөр чинь болох тэр боолыг өршөөх ёстой байсан бус уу?” гээд, ихэд хилгэнэн уурлаж, өр ширээ бүгдийг буцаан төлөх хүртэл нь түүнийг зандалчинд тушаажээ” гэсэн байдаг (Матай 18:32-34).

Гомдож хорссон хүн өөрийнхөө үйлийн эрхээр хоригдол болж, ууртай, шантарч цөхөрсөн, гансарсан, үүрэг хариуцлагаа бодож чадахгүй болсон эсвэл Бурханаас өөрт нь өгсөн хүмүүстэй харилцах харилцаанд баярлаж чадахгүй болсон байдаг.

• ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

□ Өршөөлийн утга учрыг ойлгох нь

Шударга бус нярвын тухай сургаалт зүйрлэлд тухайн өртөн өршөөл гуйгаагүй, харин төлөх хугацааг уртасгаж өгөхийг хүсч гуйсан байна. “...Эзэн, намайг тэвчин хүлцэнэ үү. Би танд бүгдийг буцааж төлнө” (Матай 18:26).

Түүнийг өрөө хэзээ ч төлж чадахгүйгээ ухаараасай гэсэндээ эзэн нь түүнийг зандалчинд тушаасан. Хэрэв тэр өршөөл гуйсан бол эзэн нь түүний бүх өрийг цайруулах байсан. Ийнхүү тэр өршөөл үзсэнээр өөрийг нь гомдоогчдыг өршөөж сурах байсан.

Гомдол хорслын цайзуудыг нураах ЗЭВСГЭЭ ОЙЛГОХ НЬ

• БЭЛТГЭЛ

Хэрвээ бид Сатанд “газар” өгсөн бол түүний захирагчид, бузар муугийн хүч, харанхуйн удирдагчдын нөлөөн дор ордог.

Гомдол хорсол тээснээр “*диаволд байр бүү өг*” гэж сэрэмжлүүлсэн номд мөн “... бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш...” [харин энэхүү ертөнцийн харанхуйн захирагчид, эрх баригчид, хүчнүүд, өндөрлөг газар дахь сүнсний бузар муугийн эсрэг] (Ефес 6:12) байдаг гэжээ.

Сатаныг ялж, түүний цайзуудыг нураах алхмуудыг Бичээсийн дараах хэсэгт хэлж өгсөн байна.

• ТЭД ТҮҮНИЙГ ЯЛСАН. ЮУГААР?

“Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ” (Илчлэлт 12:11).

□ Хурганы цус

Христийг загалмайд цовдлогдоход Сатан бүх хүчнийхээ хамт тэнд байсан. Есүс загалмайд хадагдахдаа Сатаны мэдэлд байсан хуулийн дансыг булааж авсан юм.

Сатаныг дэлхийн хүн нэг бүрийг захирах мэдэлтэй болгосон энэхүү өрийн данс түүнд байсан юм. Есүс үүнийг загалмайд хадаад дээр нь бичсэн зүйлийг цусаараа далдлан арилгасан байна.

Тэгээд тэнгэрийн улсад Сатаныг “олны нүдний өмнө харуулах үзүүлдбэр” болгожээ. Энэ нь Ромын цэргийн жанжин дайнд ялаад буцаж явахдаа хотын гудамжаар дайснаа туун явж тэд ялагдсан тул одоо ямар ч эрх мэдэлгүй, хүчгүй

болсон гэдгийг үзүүлдэг парадтай адил юм.

Христийн загалмайн ажлыг харахад Сатан ямар ч эрх мэдэлгүй бөгөөд харин Христийн ажлыг үгүйсгэж, үгийг нь дагахгүй байгаа тохиолдолд л биднийг захирах боломжтой болдог юм. Дараах ишлэлүүдээс энэ хүчирхэг үнэнийг харж болно. Үүнд:

“Та нар гэм нүглүүд болон махан биеийн хөвч хөндөх ёслолоосоо болж үхсэн байхад Тэр бидний бүх гэм нүглийг уучлаад, та нарыг Түүнтэй хамт амьд болгосон бөгөөд бидний эсрэг зарлигуудаас бүрдсэн, бидэнд дайсагнаж байсан өрийн дансыг хүчингүй болгов. Тэр үүнийг загалмайд хадаж замаасаа зайлуулжээ. Захирагчид болоод эрх баригчдыг зэвсэггүй болгоод, Тэр тэднийг загалмай дээр ялж, тэднийг нийтэд үзүүлэн болгов” (Колоссай 2:13-15).

“...Мөн итгэмжит гэрч ба үхэгсдээс анх төрсөн бөгөөд газрын хаадын захирагч Есүс Христээс... биднийг хайрладаг бөгөөд Өөрийнхөө цусаар биднийг нүглээс минь чөлөөлсөн...Түүнд” (Илчлэлт 1:5-6).

□ Тэдний гэрчлэлийн үг

Бид Христэд итгэж, амьдралыг маань удирддаг махан биеийн үйлсийг хаяж гэмшсэнээр Түүний хийсэн хүчирхэг ажилд өөрсдийгөө хамааруулдаг (Колоссай 2:6-12-ыг үз).

Энэхүү үнэнийг гэрчлэх арга зам нь гомдол хорслын гэм нүглээ улайж, Сатаны эзэлж авсан газрыг түүнээс буцаан авч өгөхийг Бурханаас гуйн, Библид нийцэхгүй бодол санааны цайзуудыг нурааж, өөрсдийг маань гомдоосон хүмүүсийг уучлан өршөөх явдал юм.

Бурхан биднийг Христийн улмаас уучилдаг тул бид бусдыг уучилдаг.

Авах арга хэмжээ:

1. Гомдож хорссон гэм нүглээ илчлэн улай.

Бидний олонх нь гомдол хорслоо байдаг л зүйл гэж хаацалдаг. Өөрсдийг маань гомдоосон хүмүүсийн учруулсан хохирлыг дахин дахин бодож нөгөө хүнийг буруутгаснаар өөрийгөө зөвтгөдөг. Түүнчлэн “Би хорсоогүй ээ. Зүгээр л маш их гомдсон байхгүй юу” гэх мэтээр хорслоо үгүйсгэдэг. Үнэндээ бид гомдоогчоо огт хайрлахаа больдог бөгөөд “Гэрлийн дотор байдаг гэж хэлчихээд ах дүүгээ үзэн яддаг нэгэн бол одоо хүртэл харанхуйн дотор байгаа юм” (1 Иохан 2:9) гэж Бурхан хэлсэн байдаг. Харанхуй бол Сатаны хаанчлалын газар учраас гомдол хорсол тээгч нэгэн нь гэм нүгэл дотроо, Сатаны хүчний дор амьдарч байгаа хэрэг юм.

Гэлээ ч гэсэн “Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ” (1 Иохан 1:9).

2. Эзлэгдсэн газрыг буцаан авч өгөхийг Бурханаас гуй.

Ефес 4:26-27-д хэлсний дагуу өөрсдийн уур хилэн дээр нар жаргаах бүртгээ бид Сатанд газар өгчихдөг. Бид эдгээр тохиолдол бүрд Сатанд алдчихсан газрыг маань буцааж авч өгөөч гэж Бурханаас гуйх ёстой. Дуулал 23:3-д “Тэр миний сэтгэлийг сэргээдэг...” гэж хэлсэн тайвшралын үгийнх нь дагуу Бурхан бидний залбирлыг сонсоно гэсэн баталгаа бидэнд байгаа. Сэргээх гэдэг үг еврей хэлэнд “эхэлсэн газартаа буцаж ирэх” гэсэн утгатай байдаг.

Эзэн Есүс Христийн цус, хүчирхэг нэрээр Сатаныг зэмлэж, Христ Өөрийн үхэл, оршуулга, дахин амилалтаар ялж авсан тэр газрыг буцааж авч өгөхийг бид Бурханаас гуйх хэрэгтэй.

3. Цайзуудыг үнэний хүчээр нураа.

Бидний алдчихсан тэр газрыг буцааж авч өгөх нь Бурханы хариуцлага, харин эзэлсэн газар дээрээ Сатаны барьж байгуулчихсан цайзуудыг эвдлэн нураах нь бидний үүрэг хариуцлага билээ. Бурхан бидэнд энэ үүргийг биелүүлэх үнэний хүчирхэг зэвсгээ өгсөн байгаа. “Учир нь бидний байлдааны зэвсэг бол махан биенийх биш [хариугаа хорсолтойгоор авах], харин цайзуудыг эвдэж нураах Бурханы хүчит зэвсгүүд юм” (2 Коринт 10:4).

Бид Сатанаас хүлээж авсан буруу санаа бодол, хуурамч дүгнэлт бүрээ илрүүлэн гаргаж устгах зорилго тавин Бичээсийг уншиж, цээжилж тогтоон, тунгааж бясалгах замаар “үнэний цамхаг”-ийг барьж байгуулах ёстой.

4. Гомдоогчоо уучлан түүнд өршөөл үзүүд.

Одоо бид гомдол хорсол нь сүнсэнд ямар сүйрэл авчирдгийг, уучлал нь өршөөлийн нэг тал гэдгийг ойлгосноор Христ биднийг хэрхэн уучилсан тэр л байдлаар өөрсдийг маань гомдоосон хүмүүсийг бүрэн уучлах хүсэл төрөх учиртай. “Аливаа хорсол, уур хилэн, шуугиан, гүтгэлэг нь бүх бузар муугийн хамт та нараас зайлаг. Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг нэгнийгээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд” (Ефес 4:31-32).